



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 7 сарын 20 өдөр

Дугаар 262

Улаанбаатар хот

“Аргай бэст ҮЦК” ХХК-ийн
арилжаанд оролцох эрхийг
сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх захирлын 2016 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 183 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан “Аргай бэст ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Гишүүнчлэлийн гэрээ”-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг “Аргай бэст ҮЦК” ХХК /Д.Ариунболд/-д анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР